



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

“ТОЛГОЙТ ДЭД ТӨВ БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103 /

ГАРЧИГ

Зургийн жагсаалт	2
Хүснэгтийн жагсаалт	3
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2. Толгойт дэд төвийн танилцуулга	5
1.2.1. Байршил	5
1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал	6
1.2.3. Төслийн ус болон цахилгаан хангамж	9
1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал	9
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	10
2.1. Толгойт дэд төв орчмын агаарын чанар	10
2.1.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд	10
2.1.2. Агаарын массын хөдлөлзүй	11
2.2. Толгойт дэд төв орчмын усан орчин	12
2.2.1. Гадаргын усны чанар	12
2.2.2. Газар доорх усны чанар	19
2.3. Толгойт дэд төв орчмын хөрсөн бүрхэвчийн хими, физик шинж чанар	26
2.4. Толгойт дэд төвийн ургамлын нөмрөг	28
2.5. Толгойд дэд төв орчмын амьтдын тархалт	29
2.6. Төслийн талбайн нийгэм, эдийн засгийн товч тодорхойлолт	29
3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	32
3.1. Уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	32
3.2. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	33
3.3. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	34
3.4. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	35
3.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	36
3.6. Ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, хамрах хүрээ	37
3.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл, хамрах хүрээ	37
3.8. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж болзошгүй нөлөөлөл тодорхойлох	38
3.9. Болзошгүй сөрөг нөлөөллийн тархалтын түвшнийг тодорхойлох	39
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ..	41
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	45
5.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):	45
5.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC)	50
5.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):	54
5.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC)	60
5.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	64
5.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):	68
5.7. Сургалтын төв барих ажил (TBC):	73
5.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	78
5.9. Талбайн цэвэрлэгээний ажил (SC):	82
5.10. 106-р сургуулийн хөл бөмбөгийн талбайн тохижилт (TFS):	85
6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	88
6.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):	88
6.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC)	90

6.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	91
6.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC).....	93
6.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	95
6.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):.....	97
6.7. Сургалтын төв барих ажил (TBC):	99
6.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	101
6.9. 106-р сургуулийн хөл бөмбөгийн талбайн тохижилт (TFS):	103
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	105
7.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):.....	105
7.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	105
7.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	106
7.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC).....	107
7.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	108
7.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):.....	109
7.7. Сургалтын төв барих ажил (TBC):	109
7.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	110
8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	112
9. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	113
9.1. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	113
9.2. Нөхөн сэргээлтийн үе шат	114
9.3. Нөхөн сэргээлтийн нийт зардал	115
9.3.1. Нөхөн сэргээлтийн зардлын хураангуй	115
9.3.2. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	116
10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	117
11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	117
12. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	118
13. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ).....	119
13.1. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11 болон TRDH14):.....	119
13.2. Мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт (TEC).....	120
13.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP):.....	121
13.4. Салбар шугам холбох багц ажил (SHTSC).....	121
13.5. Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн ажил (SHTL):	122
13.6. Эрүүл мэндийн төв барих ажил (PHC):.....	123
13.7. Сургалтын төв барих ажил (TBC):	123
13.8. Ерөнхий боловсролын сургууль барих ажил (TSC)	124
13.9. Талбайн цэвэрлэгээний ажил (SC):.....	124
13.10. 106-р сургуулийн хөл бөмбөгийн талбайн тохижилт (TFS):	125
Хавсралт	126

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил	5
Зураг 2. Толгойт дэд төв төслийн талбайн гадаргын морфометрийн зарим үзүүлэлт	10
Зураг 3. Толгойт дэд төв орчмын агаарын бохирдлын эх үүсвэр	10
Зураг 4. 1. Air mass movement.....	11
Зураг 5. Нарангийн булгийн сорьц авсан цэгүүд.....	12
Зураг 6. Бактерийн ерөнхий тоо	14
Зураг 7. Гадаргын усны эрсдэлийн үнэлгээний зураглал	15
Зураг 8. Оршуулгын газрын төгсгөл хэсэг	16
Зураг 9. Оршуулгын газрын төгсгөл хэсгийн дээд талын харагдах байдал	16
Зураг 10. Оршуулгын газрын төсгөл хэсгийн доод талын харагдах байдал	16
Зураг 11. Нарангийн гол гэр хороолол дундуур урсаж байна, ШУТБ № 222-ын хажууд	17

Зураг 12. Сувгийн усны сорьц авсан цэгүүд	18
Зураг 13. Толгойт дэд төвийн усан орчны мониторинг судалгаанд хамрагдсан хуудгууд.....	20
Зураг 14. Ус түгээх байр	20
Зураг 15. Ш.Доржийн худаг.....	21
Зураг 16. 221-р худаг.....	22
Зураг 17. “ТЭСО” ХХК-ны худаг.....	22
Зураг 18. “Экстид” ХХК-ны худаг.....	23
Зураг 19. Отгонбаярын худаг.....	23
Зураг 20. Гүний усанд агуулагдах бичил элементийн агууламж	24
Зураг 21. Гүний усанд агуулагдах As-ийн тархалт, эрсдэлийн зураглал.....	25
Зураг 22. Хөрсний урвалын орчин	26
Зураг 23. Хөрсний ялзмагийн агууламж, %.....	27
Зураг 24. Хөрсний цахилгаан дамжуулах чанар	27
Зураг 25. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5)-ийн агууламж	28
Зураг 26. Хөрсөн дэх калийн исэл (K2O)-ийг агууламж	28
Зураг 27. Төслийн талбайгаас гарсан агаарын массын тархалт (HYSPLIT загвар)	32

Хүснэгтийн Жагсаалт

Хүснэгт 1. Төслийн хүрээнд хэрэгжих дэд төслүүдийн тодорхойлолт.....	6
Хүснэгт 2. Гадаргын усны химийн шинжилгээний дүн, мг/л.....	12
Хүснэгт 3. Бичил элементийн аюулын тоо хэмжээ.....	13
Хүснэгт 4. Нарангийн голын усны чанарын мониторингийн нэгдсэн дүн.....	14
Хүснэгт 5. Бичил элементийн аюулын тоо хэмжээ.....	18
Хүснэгт 6. Толгойт орчмын сувгийн усны чанарын мониторингийн нэгдсэн дүн	19
Хүснэгт 7. Толгойт дэд төвийн усан орчны мониторингийн уст цэгүүд	19
Хүснэгт 8. Гүний усны химийн шинжилгээний дүн, мг/л	21
Хүснэгт 9. Усны чанарын эрсдэлийн үнэлгээний аюулын тоон утга	24
Хүснэгт 10. Толгойт дэд төвийн мониторингийн хяналтын цэгийн байршил ба бүртгэл.....	29
Хүснэгт 11. Толгойт дэд төвийн газар нутагт хамрагдах хүн амын тоо	30
Хүснэгт 12. Уур амьсгалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	32
Хүснэгт 13. Цэвдэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ.....	33
Хүснэгт 14. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ.....	34
Хүснэгт 15. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	35
Хүснэгт 16. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	36
Хүснэгт 17. Ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	37
Хүснэгт 18. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн хамрах хүрээ	37
Хүснэгт 19. Нөлөөллийн үзүүлэлт ба оноо	38
Хүснэгт 20. Нөлөөллийн зэргийн шалгуур	39
Хүснэгт 21. Нөлөөллийг үнэлэх шалгуур	39
Хүснэгт 22. Төслийн байгаль орчныг хянах хүснэгт.....	40
Хүснэгт 23. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ.....	42
Хүснэгт 24. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй.....	44
Хүснэгт 25. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TRDH11 болон TRDH14).....	45
Хүснэгт 26. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TEC).....	50
Хүснэгт 27. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TFP багц)	55
Хүснэгт 28. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (Салбар шугам багц)	60
Хүснэгт 29. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (SHTL багц).....	64
Хүснэгт 30. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (PHC багц)	68
Хүснэгт 31. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TBC багц).....	73
Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TSC багц).....	78
Хүснэгт 33. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (SC багц)	82
Хүснэгт 34. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (TFS багц)	85
Хүснэгт 35. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	113
Хүснэгт 36. Нөхөн сэргээлтийн зардлын нэгдсэн дүн	115
Хүснэгт 37. Нөхөн сэргээлтийн зардлын нэгдсэн дүн	115
Хүснэгт 38. Газар эзэмшлийн нөхцөл байдал	117
Хүснэгт 39. “Толгойт” дэд төв нөхөн олговор	117
Хүснэгт 40. БОМТ хэрэгжилтийг оролцоогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	118

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр бөгөөд төсөл хэрэгжсэнээр агаар, хөрс, усны бохирдол буурч, тухайн нутаг дэвсгэр дэх оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах эрх хангагдана гэж үзэж байна.

Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь УБ хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь: (i) эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох; (ii) ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох; (iii) зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм.

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 27 ажил хамаарч байгаагаас 2023 оны 06-р сарын байдлаар 2 ажлын бүтээн байгуулалт явагдаж бусад ажлууд хэрэгжиж эхлээгүй байна.

Толгойт дэд төвийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2023 оны 5-р сард БОАЖЯ-аар батлагдсан. Тус БОННУ-ний хамтаар 2023-2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) батлагдсан. 2023-2026 оны БОМТ болон төслүүдийн 2023 оны үйл ажиллагаатай уялдуулан 2023 оны БОМТ-г “Байгаль орчин, ногоон хөгжлийн яам”-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 дугаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Толгойт дэд төв

Төслийн дугаар: 13/3270

Төслийн зорилго:

Гэр хороололд орон сууц, хүүхдийн цэцэрлэг, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг бий болгоход төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгч:

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж”

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Бага тойрог-1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө Г корпус/415 тоот.

Холбоо барих утас: 9103-3373, 9976-7000-3099,

Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Төслийн зохицуулагч: Д.Авирмэд, Утас:7000-3099


Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

3.Мөнх-Оргил 99118303, munkh-orgil@ub-subcenter.mn

1.2. Толгойт дэд төвийн танилцуулга

1.2.1. Байршил

Толгойт дэд төв нь нийт 551,4 га газар нутгийг хамрах бөгөөд засаг захиргааны хувьд Сонгинохайрхан дүүргийн 1, 2,3, 20, 35 дугаар хороод багтдаг.



Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил

1.2.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 27 ажил хамаарч байгаагаас 2023 оны 06-р сарын байдлаар 2 ажлын бүтээн байгуулалт явагдаж бусад ажлууд хэрэгжиж эхлээгүй байна.

Хүснэгт 1. Төслийн хүрээнд хэрэгжих дэд төслүүдийн тодорхойлолт

№	Багцын дугаар	Багцын нэр	Хийгдэх ажил	2023 оны явц
1	ТЕС-А	Толгойт дэд төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт	Толгойт дэд төвд цахилгаан холбоо, шугам сүлжээ <ul style="list-style-type: none"> Холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн байгууламжийн ажил 25м өндөр цамхаг 1ш Зам дагуух 68ш LRP камер, 34ш өргөн өнцөгт камер, 34ш 360о PTZ камер ба 34ш Г-хэлбэрт камерын шон ба суурийн хамт ханган нийлүүлж угсрах Эх үүсвэр талын 110/10кВ-ын "Толгойт" дэд станцын байршилд 10кВ-н ХХБ, Удирдлагын байрны иж бүрэн барилга угсралтын ба түүний холболтын ажил 110/10кВ-ын "Толгойт" дэд станцын хашаанд хийгдэх газардуулга, аянга хүлээн авагч, кабель шугамын зөөн шилжүүлэх, буулгах ажил Гэрэлтүүлэгч бүхий аянга зайлуулагч матчийг, гэрэлтүүлгийн удирдлагын самбарын хамт нүүлгэн шилжүүлж угсрах, Төлөвлөж буй хуваарилах байгууламжуудтай ажлын зурагт тусгагдсаны дагуу 4-н өөр фидер шугамуудыг холбох ажил 	Ажил эхлээгүй. 6-8-р сар гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
2	ТЕС-В	Толгойт дэд төвийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> Толгойт дэд төвд цахилгааны дэд станц, 10кВ цахилгаан түгээх кабель шугам 10/0.4кВ-ын 2Х630кВА трансформатор бүхий иж бүрэн хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажил -9ш Шинээр төлөвлөж буй цахилгааны дэд өртөөнүүдийн тэжээлийн 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын ажил (3x150~240мм²) 	Ажил эхлээгүй. 6-8-р сар гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
3	ТЕС-С	Толгойт дэд төвийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> Толгойт дэд төвийн цахилгаан түгээх байгууламж, 10кВ цахилгаан түгээх кабель шугам 10кВ-н хуваарилах удирдлагын байр-1, удирдлагын байр 1 	Ажил эхлээгүй. 6-8-р сар гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
4	TRDH11A	Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (3-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> Автомашинны зогсоол: НЭТ-3-д 7618.7м² талбай бүхий 180 авто машины зогсоол, орц, гарц Автозамын дагуух ба ойролцоох ариутгах татуургын шугам хоолой ба худгууд Одоо байгаа холбооны худаг, сувагчлалын байгууламж ба цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах Автозамын доорх шугам сүлжээг хүчитгэх, кабелийн хамгаалалтын хоолойнууд угсрах 	Ажил эхлээгүй. 8-р сард гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
5	TRDH11B	Толгойт дэд төвийн авто зам болон	<ul style="list-style-type: none"> А4 автозам ба дагалдах замын байгууламж, тоноглолууд 	Ажил эхлээгүй. 8-р сард гэрээ

		дагалдах ИШС (4-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> • Бохир усны шугам сүлжээ • Дэд өртөө КТПН 63кВА • Автомашины зогсоол: 42-р сургуулийн урд хийгдэх нийт 444м2 талбай бүхий 16 машины авто зогсоол ба туслах зам: НЭТ5-д 155.3 м2 автозам • Одоо байгаа холбооны худаг, сувагчлалын байгууламж ба цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах 	байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
6	TRDH11C	Толгойт дэд төвийн насосын станц болон усан шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> • Усан хангамжийн сүлжээ • Ус хангамжийн шугам хоолой ба худгууд • Насос станц Q=4600м3/х • Насос станцын иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай • Одоо байгаа цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугамыг шилжүүлэх, буулгах ба шинээр татах 	
7	TRDH11D	Толгойт дэд төвийн авто зам	<ul style="list-style-type: none"> • А1 автозам ба дагалдах замын байгууламж, тоноглолууд Автозамын гэрлэн дохио 3 байршилд • Одоо байгаа холбооны худаг, сувагчлалын байгууламж ба цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах • Автозамын доорх шугам сүлжээг хүчитгэх, кабелийн хамгаалалтын хоолойнууд угсрах 	
8	TRDH14A	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> • Автомашины зогсоол 2ш: НЭТ1-д 145.7м2 талбай бүхий 7 авто машины зогсоол, НЭТ4-т 370.4м2 талбай бүхий 11 авто машины зогсоол • 3ш ус дулаан дамжуулах төвийн иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай: УДДТ-2, УДДТ-3, УДДТ-4 • Гадна дулааны шугам сүлжээ Салбар-2 • 3 ш ус дулаан дамжуулах төвийн иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай: УДДТ-2, УДДТ-3, УДДТ-4 • Гадна дулааны шугамтай явах ба ойролцоох ус хангамжийн шугам хоолой ба худгууд • А2 автозам ба дагалдах замын байгууламж, тоноглолууд • А5 автозам ба дагалдах замын байгууламж, тоноглолууд 	
9	TRDH14B	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> • А3 хэмжээтэй авто зам, замын байгууламж • Бохир усны шугам сүлжээ • цэвэр усны шугам • Төвлөрсөн дулааны шугам сүлжээ • УДДТ 1, 5 • Гадна дулааны шугамтай явах ба ойролцоох ус хангамжийн шугам хоолой ба худгууд • Автозамын дагуух ба УДДТ-ийн ариутгах татуургын шугам хоолой ба худгууд 	

			<ul style="list-style-type: none"> Одоо байгаа цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах Автозамын доорх шугам сүлжээг хүчитгэх, кабелийн хамгаалалтын хоолойнууд угсрах 	
10	TBC	Толгойт дэд төв сургалтын төв	<ul style="list-style-type: none"> Тэнхлэгээрээ 50.0 х 33.0 м хэмжээтэй, хагас нум хэлбэртэй болон тэгш өнцөгтийн блокоос бүрдсэн 2 давхар, 2081 м2 талбай 	2022 оны 7-р сараас эхэлсэн. 2023 онд ажил дуусна.
11	PHC	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төв	<ul style="list-style-type: none"> 15 ортой, дэд төвийн иргэдийн эрүүл мэндийн төвийн барилга Зоорьгүй, 2 давхар, барилга нь тэнхлэгээрээ 43.20*16.00м хэмжээтэй, нийт талбай 1251.9м² 	Ажил эхлээгүй. 10-р сард гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
12	SHTL-A	Толгойтын дэд төвүүдийн ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбай (Ландшафтын байршил 1,2,3,4)	<ul style="list-style-type: none"> 42-р сургуулийн гадна тохижилт, спорт талбай 7046м² - 106 дугаар сарын гадна тохижилт, хөл бөмбөгийн талбай Толгойт дэд төв ногоон байгууламж бүхий тохижилттой талбай 	Ажил эхлээгүй. 8-р сард гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
13	SHTL-B		<ul style="list-style-type: none"> Толгойт дэд төвийн 9000м² тохижилттой талбай 	
14	SHTL-C		<ul style="list-style-type: none"> Баянхошуу дэд төвд: тохижилт 13, мод тарих 26, зүлэгжүүлэх 10, Сэлбэ дэд төвд: тохижилт 7, мод тарих 25, зүлэгжүүлэх 11, авто машины зогсоол 1 	
15	SHTL-D		<ul style="list-style-type: none"> 35-р сургуулийн гадна талбайн тохижилт, - Баянхошуу 50 айлын орон сууцны гадна тохижилт, - Баянхошуу бизнес инкубатор төвийн гадна авто зогсоол, тохижилт 	
16	SHTL-E	81-р цэцэрлэгийн зүүн талд гадна тохижилтын ажил	<ul style="list-style-type: none"> Явган зам 497.13м² Дугуйн зам 154.09м² Ногоон байгууламж 358м² Хүүхдийн тоглоомын талбай 240.83м² Түр зогсоол 114.84м² Гэрэлтүүлгийн ажил Холбоо дохиоллын ажил 	
17	TSC	Толгойт дэд төвийн бага сургууль. 320суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Толгойт дэд төвийн бага сургууль. 320суудалтай, Барилга нь 5 блокоос бүрдэнэ. Барилгын ашигтай талбай 	Ажил эхлээгүй. 8-р сард гэрээ байгуулагдахаар төлөвлөгдөж байгаа
18	SC-A	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил (1-р шат ,2-р шат)	<ul style="list-style-type: none"> 160 нэгж талбар Баянхошуу, Дамба, Толгойт 	
19	SC-B			
20	SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	<ul style="list-style-type: none"> Хийн халаалтын зуух суурилуулах ажил -9ш сургуульд нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил - 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил - 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил - 1ш сургууль 	
21	TFP	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (1-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> Толгойт дэд төвийн үерийн хамгаалалт, ус зайлуулах Үерийн усны хамгаалалтын суваг Тунгаах байгууламж 2ш Далд хоолой 2 байрлалд Одоо байгаа далд хоолойг өргөсгөх 1 байрлалд Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд 	
22	SHTSC-A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	<ul style="list-style-type: none"> Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил 	

23	SHTSC-B	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	<ul style="list-style-type: none"> • Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш 	
24	SHTSC-C	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт	<ul style="list-style-type: none"> • Ариутгах татуургын шугам – 1.5км • Дулаан хангамжийн шугам – 1 км 	
25	SHTSC-D	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт	<ul style="list-style-type: none"> • 35-р сургууль / сэлбэ дэд төв/ • 50-р байр /Баянхошуу дэд төв/ шугам холболт 	
26	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> • Толгойт дэд төвд (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой • Үерийн усны хамгаалалтын суваг • Автомашин болон явган хүний гарц 5 байрлалд • Далд хоолой 	Ажил явагдаж байгаа. 2023 оны 10-р сарын 30-нд дуусгахаар төлөвлөж байгаа.
27	TFS	106-р сургуулийн хөл бөмбөгийн талбай.	<ul style="list-style-type: none"> • 7608м² талбайд хийгдэнэ. 	Ажил эхлээгүй.

1.2.3. Төслийн ус болон цахилгаан хангамж


Толгойт дэд төвийн барилгын ажил болох Замын барилга, Цэвэр усны шугам хоолой, цахилгаан хангамж, Дулаан хангамж, сургууль, эмнэлэг гэх мэт ажлын хүрээнд 10-12 компани барилгын ажил гүйцэтгэх бөгөөд. Тухайн газар ажиллах хүн хүчний хувьд нэг компани /Аж ахуйн байгууллага/ 20-30 хүнтэй буюу нийт 200-250 хүн ажиллах болно.Барилгын ажлын хүрээнд ашиглах усыг төвлөрсөн шугам болон УСУГ-ын харьяа гүний худгуудаас авч хэрэглэнэ. Толгойт дэд төвийн цэвэр усан хангамж нь дараах эх үүсвэртэй бөгөөд 3–р үе шатны хүрээнд СХД-ийн 1,2, 3 болон 34,35 дугаар хороонд Төвлөрсөн шугамд холбогдсон 12 ширхэг худаг, Ахуйн хэрэглээний 44 худаг байна.

1.2.4. Төсөлд ашиглах түүхий эд, материал

Толгойт дэд төв төслийн бүс орчимд байрлах тусгай зөвшөөрөл бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудаас түүхий эд, материалыг татахаар төлөвлөж байна.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Толгойт дэд төвийн газар нутаг нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамаарна. Тус газар нутаг нь 1252-1398 м өндөрт өргөгдсөн, уулын хөндий хотос газраар 0-6⁰ бөгөөд хот суурин газар төлөвлөхөд геомфорологийн төвөгшил бага юм.




Зураг 2. Толгойт дэд төв төслийн талбайн гадаргын морфометрийн зарим үзүүлэлт

Уур амьсгалын мужлалаар хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй бүсэд оршино.

2.1. ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ОРЧМЫН АГААРЫН ЧАНАР

2.1.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Агаарын бохирдлын эх үүсвэрийг талбайн, шугаман, цэгэн эх үүсвэр гэж 3 ангилан авч үзлээ (Зураг 3). Төслийн талбайд тархах агаар бохирдуулагч эх үүсвэрийг дээрх 3 ангиллаар ангилав. Төслийн талбайд орших уурын зуухнууд нь цэгэн эх үүсвэр юм. Уурын зуухны хүчин чадал, байршил зэрэг мэдээллийг хавсаргав (Хавсралт-1).




Зураг 3. Толгойт дэд төв орчмын агаарын бохирдлын эх үүсвэр

Гэр хорооллын айл өрхүүдийн яндангаас ялгарах хийн хаягдлыг эх үүсвэрийг талбайн эх үүсвэр болгон авч нэгж талбайн эх үүсвэрийн хаягдлын хэмжээг тодорхойлохдоо тухайн талбайд багтах гэр хорооллын тоог нэг гэрээс ялгарах хаягдлын хэмжээгээр үржүүлэн эзлэх талбайд нь хувааж олдог байна. Түүнийг нэгж хугацаанд, нэгж талбайгаас ялгарах массаар илэрхийлэх бөгөөд талбайн эх үүсвэрийн геометр хэмжээнээс хамаарч харилцан адилгүй байна. Төслийн талбайд хамаарах гэр хорооллын айл өрхүүдийг 9 талбайн эх үүсвэрт хуваасан болно.

Шугаман эх үүсвэрт шороон зам орно. Шороон замыг төслийн талбайн хүрээнд Google Earth платформын мэдээг ArcGIS програмд оруулж дижитайз хийж зураглав. Төслийн талбайн хүрээнд шороон замын нийт урд 69043.78 м буюу 70 орчим км байна.

2.1.2. Агаарын массын хөдлөлзүй

Дүүргийн хойноос баруун урагш чиглэсэн Рашаантын урт хөндийд -20 хэмээс хүйтэн өргөн зурвас байх бөгөөд уг хөндийн хойд хэсэг Нарийны, Хутагт Өндөр, Багаагийн амын бэлчир өргөн хөндийд -24 - -21.5°C, дунд хэсэгт -22 – -21.5°C, урд хэсэгт -23.5 - -21.5°C-ийн хүйтний голомт байна. Сонгино хайрхан уулаас зүүн тийших хөндийд -22.5 - -22 °C-ийн хүйтэн голомт байна. Баруун хойд хэсэгт орших Согоот, Цагаан чулуут уул, түүнээс урагш орших Хөндлөн уул, Хар модтын даваа, дүүргийн зүүн дунд хэсэгт орших Улаан дэл, Толгойтын уул тус тус -17.5 - -17°C-ийн голомт, -19.5 - -18°C-ийн зурвас үүсгэж байна. Толгойт, Баянхошууны гэр хороолол -21.5 - -21°C-д, Толгойтын баруун, зүүн салааных -20.5 - -19°C-д байна.




Зураг 4. 1. Air mass movement

2.2. ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ОРЧМЫН УСАН ОРЧИН

2.2.1. Гадаргын усны чанар

Нарангийн гол

Нарангийн булгийн эх, оршуулгын хашааны доод тал, гэр хороолол дунд зэрэг 3 цэгт хээрийн судалгааны үеийн хэмжилтээр усны температур 4.78-10.48°C-ын хооронд байгаа бол усны орчин сул шүлтлэг рН 7.48-7.71 байна.



Нарангийн булаг эх



Оршуулгын доод тал



Гэр хороолол дунд

Зураг 5. Нарангийн булгийн сорьц авсан цэгүүд

Лабораторийн шинжилгээгээр тус булгийн ус нь гидрокарбонатын ангийн, кальцийн булгийн, 1, 2-р төрлийн устай байна. Булгийн ус урсгалынхаа дагуу эрдэсжилт, хатуулаг нь нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, булгийн эхийн ус цэнгэг, зөөлөвтөр байснаа урсгалынхаа дагуу өөрчлөгдөж гэр хорооллын дундуур урсах хэсэгтээ цэнгэгдүү, хатуу болж эрдэсжилт, хатуулгийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна.

Булгийн ус бүх цэгт “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” стандартын шаардлага хангаж байгаа боловч “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”-той харьцуулахад оршуулгын газрын төгсгөлөөс авсан цэгт ууссан бодисуудын хуурай үлдэгдлийн хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, гэр хорооллын дундаас авсан цэгт нитритийн азотын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, ууссан бодисуудын хуурай үлдэгдлийн хэмжээгээр “Бохирдолттой” гэсэн ангилалд тус тус хамаарч байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Гадаргын усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан газрын нэр	MNS 4586:1998	ГУЦЗАН-НЫ “цэвэр”	Нарангийн булаг-1	Нарангийн булаг-2	Нарангийн булаг-3	Суваг-1	Суваг-2	Суваг-3	
Сорьц авсан хугацаа /2022/			07.30	07.30	07.30	07.28	07.28	07.28	
Эрдэс, мг/л		300	293	387.3	631.4	261.1	283.2	295.4	
Хатуулаг, (мг-экв/л)			3.16	3.78	7.02	2.11	2.54	2.48	
ПИЧ	10	5	1.6	1.28	2.08	7.84	14.24	11.84	
NH ₄ ⁺	0.64	0.06	0	0	0	3.5	0.4	0.4	
NO ₂ /NO ₃	0.065/39.9	0.016/13.3	0.0/1.0	0.0/2.0	0.05/12	3.2/10	2.8/8	0.1/1.0	
Индекс			C _{CaI}	C _{CaI}	C _{CaII}	C _{CaNaII}	C _{CaII}	C _{CaNaI}	
Үндсэн элементүүд	CO ₃ ⁻ /HCO ₃ ⁻	-	0/201.3	0/268.4	0/329.4	0/91.5	0/115.9	0/189.1	
	Cl ⁻	300	6	8.5	32	36.6	27.7	13.5	
	SO ₄ ²⁻	100	100	13	14	98	45	17	
	Na ⁺ +K ⁺	-	-	13.7	27.2	34.9	32.1	31	31.1
	Ca ²⁺	-	90	49.7	53.9	101	34.7	41.9	33.3
Mg ²⁺	-	30	8.3	13.3	24.1	4.6	5.5	10	

Бичил элементийн шинжилгээний дүн

Нарангийн голын эх, оршуулгын газрын доор, гэр хорооллын дундаас авсан дээжид хийсэн шинжилгээний дүнгээр эдгээр цэгүүдэд Al, Cr, Cu, Fe, Mn, P, Ti, V, Zn, Be, Se, Zr, Ag, Ag, In, Sn, Cs, La, Ce, Pr, Nd, Sm, Gd, Tb, Ho, Tm, Lu, Hf, Ta, Hg, Tl, Pb, Bi, Th зэрэг элементийн агууламж багажийн мэдрэх чадвараас бага байв. Бусад элементийн хувьд АНУ-ын Байгаль орчны агентлаг, Канадын Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хоруу чанарын лавламж утгын өгөгдлийн санд орсон 8 элементүүдийн аюулын тоон утгыг тооцоолов (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Бичил элементийн аюулын тоо хэмжээ

Эх үүсвэр/бичил элемент	Ba	Mg	Sr	Ni	Mo	As	Cd	U
Нарангийн булгийн эх	0.0 0	0.0 0	0.0 2	2.4 3	0.0 1	0.1 9	0.0 0	0.1 9
Нарангийн булаг, оршуулгын газрын доороос, шургаж гарч ирж байгаа	0.0 3	0.0 0	0.0 3	2.4 3	0.0 1	0.1 2	0.0 0	0.2 4
Нарангийн булаг, ШУТБ №222 хажуу талд	0.1 1	0.0 1	0.0 7	7.3 0	0.0 1	0.3 1	0.0 0	0.4 1

Эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд Ba, Mg, Sr, Mo, Cd зэрэг элементийн аюулын тоон утга 0.2-оос бага буюу хүлцэх эрсдэлтэй байна.

Никелийн (Ni) агууламж аюулын тоон утгаар Нарангийн голын эх болон дунд хэсэгт 2.43, түүнээс доош гэр хорооллын дунд 7.3 болж нэмэгдсэн бөгөөд аль ч цэгт хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл үл хүлцэх эрсдэлтэй байна.

Хүнсний (As) агууламж аюулын тоон утгаар Нарангийн голын эх, дунд хэсэгт хүлцэх эрсдэлтэй боловч гэр хорооллын дунд хэсэгт аюулын тоон утга 0.31 буюу үл хүлцэх эрсдэлтэй байна.

Ураны (U) агууламж аюулын тоон утгаар Нарангийн голын эх хэсэгт 0.19 буюу хүлцэх эрсдэлтэй, харин түүнээс доош дунд хэсэгт 0.24 буюу үл хүлцэх, гэр хорооллын дунд нэмэгдээд 0.41 буюу үл хүлцэх эрсдэлтэй байна.

Бактериологийн шинжилгээний үр дүн

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лавлагаа лабораторид бактериологийн бактерийн ерөнхий тоо, Escherichia coli, Salmonella spp, гэдэсний бүлгийн нян гэсэн 4 үзүүлэлтээр Нарангийн голын эх, оршуулгын газрын доор, гэр хорооллын дундаас 2022 оны 07-р сарын 30-ны өдөр авсан дээжид хийсэн шинжилгээний дүнгээр Escherichia coli, Salmonella spp, гэдэсний бүлгийн нян илрээгүй боловч бактерийн тоо 120 КҮН/мл буюу MNS (ISO) 6222-98 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 20 КҮН/мл-ээр их байв. Харин оршуулгын гүний, гэр хорооллын дундах цэгүүдэд бактерийн ерөнхий тоо 81-98 буюу MNS (ISO) 6222-98 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна. Булгийн эхийн орчим ямар учраас их байгааг нягтлах зорилгоор 2022 оны 10-р сарын 10-ны өдөр дахин дээж авч шинжилгээ хийлгэхэд 185 КҮН/мл буюу MNS (ISO) 6222-98 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 85 КҮН/мл-ээр их байв. Дээж авах үед малын хөлийн мөр булгийн эх орчим нэлээдгүй их, аль ч цаг хугацаанд мал их бэлчиж байв (Зураг 6). Эндээс үзвэл булгийн эх орчим малын хөлийн нөлөөгөөр бактерийн тоо өндөр гарч байж болзошгүй юм.




Зураг 6. Бактерийн ерөнхий тоо

Нарангийн голын усны чанар

Усан орчны мониторингийн судалгааны хүрээнд ерөнхий химийн 28 үзүүлэлт, бичил элементийн 57, бактериологийн 4 үзүүлэлтээр шинжилгээ хийлгэсэн дүнд холбогдох боловсруулалт хийж үзлээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Нарангийн голын усны чанарын мониторингийн нэгдсэн дүн

	“Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”	Бичил элементийн эрсдэлийн үнэлгээгээр үл хүлцэх эрсдэлтэй элемент	Бактериологи
Нарангийн булгийн эх	Цэвэр	Ni	120-185 КҮН/мл
Оршуулгын газрын төгсгөл хэсэг	Ууссан бодисуудын хуурай үлдэгдлийн хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”	Ni, U	81 КҮН/мл
Гэр хорооллын дунд	Нитритийн азотын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, ууссан бодисуудын хуурай үлдэгдлийн хэмжээгээр “Бохирдолттой”	Ni, As, U	98 КҮН/мл



Зураг 7. Гадаргын усны эрсдэлийн үнэлгээний зураглал

Нарангийн голын эхэн хэсэг: Малын хөлийн нөлөөллөөр бактерийн тоо бусад цэгтэй харьцуулахад их, MNS (ISO) 6222-98 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 20-85 КҮН/мл-аар их, ерөнхий химийн үзүүлэлтээр цэвэр, бичил элементийн агууламжаар Ni үл хүлцэх эрсдэлтэй байна.



Зураг 8. Оршуулгын газрын төгсгөл хэсэг

Нарангийн голын хөндийн баруун, зүүн хажуугаар байрлах оршуулгын газруудын дуусах төсөл, баруун аманд орших үйлдвэрийн нөлөө орохоос өмнө зурвас газраас дээж авч шинжилгээ хийлгэж, үр дүнг боловсруулахад бактерийн ерөнхий тоо MNS (ISO) 6222-98 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна. Харин ерөнхий химийн үзүүлэлтийг “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”-той харьцуулахад ууссан бодисуудын үлдэгдлийн хэмжээгээр “Бага зэрэг бохирдолтой” ангилалд орж, бичил элементийн эрсдэлийн үнэлгээгээр Ni, U зэрэг элементийн агууламжаар үл “хүлцэх эрсдэл”-тэй байна.



Зураг 9. Оршуулгын газрын төгсгөл хэсгийн дээд талын харагдах байдал



Зураг 10. Оршуулгын газрын төсгөл хэсгийн доод талын харагдах байдал

Гэр хорооллын дундах хэсэг: Оршуулгын газрын төгсгөл хэсгээс Нарангийн голын хөндийд баруун хажууд байх үйлдвэрийн нөлөөлөл, гэр хорооллын нүхэн жорлон, хатуу хог хаягдал болон бусад нөлөөлөл бүхий хуримтлагдах нөлөөлөлд өртөж Нарангийн гол урсана.



Зураг 11. Нарангийн гол гэр хороолол дундуур урсаж байна, ШУТБ № 222-ын хажууд

Гэр хорооллын дундаас авсан дээжид хийсэн ерөнхий химийн шинжилгээний үр дүнг “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”-той харьцуулахад нитритийн азотын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, ууссан бодисуудын хуурай үлдэгдлийн хэмжээгээр “Бохирдолттой” гэж гарсан. Бичил элементийн эрсдэлийн үнэлгээгээр Ni, As, U зэрэг элементийн усан дахь агууламжаар үл хүлцэх эрсдэлтэй байна.

Цэгэн бус бохирдлын эх үүсвэр буюу ус зайлуулах сувгийн усны чанар

Сувгийн уснаас 18 болон 23-р цэгийн дунд байх үерийн суваг (суваг-1), Орбитын цэргийн хотхоны арын суваг (суваг-2), 15-р цэгийн ойролцоо Орбитын суваг (суваг-3) зэрэг 3 цэгээс сорьц авсан. Сувгийн усны температур 15.02-16.91°C-ын хооронд байгаа бол усны орчин сул шүлтлэг рН 7.56-8.0 байна.



Суваг-1



Суваг-2



Суваг-3

Зураг 12. Сувгийн усны сорьц авсан цэгүүд

Хүснэгт 2-с харахад сувгийн усны химийн найрлагын хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж, катионоос суваг-1 кальци-натри, суваг-2 кальци, суваг-3 кальци-натри зонхилсон, суваг-1, 2 нь 2-р төрлийн, суваг-3 3-р төрлийн устай байна. Сувгийн ус чанарын хувьд цэнгэг, зөөлөн, бохирдолттой байна.

Суваг-1-ийн усны нитрит болон аммонийн азотын агууламж, **суваг-2**-ын нитритийн азот нь “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998” стандартад зааснаас их, **суваг-3** нь стандартын шаардлага хангаж байна. “Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”-той харьцуулахад **суваг-1** исэлдэх чанарын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, аммонийн азот болон нитритийн азотын хэмжээгээр “Маш их бохирдолттой”, **суваг-2** исэлдэх чанарын хэмжээгээр “Бохирдолттой”, аммонийн азотын агууламжаар “Их бохирдолттой”, нитритийн азотын хэмжээгээр “Маш их бохирдолттой”, **суваг-3** исэлдэх чанар, нитритийн азотын хэмжээгээр “Бохирдолттой”, аммонийн азотын агууламжаар “Их бохирдолттой” гэсэн ангилалд тус тус хамаарч байна (Хүснэгт 2).

Бичил элементийн шинжилгээний дүн

Дээж авч шинжилгээ хийсэн 3 сувгийн усанд Cr, Cu, V, Be, Se, Ag, Sn, Te, Hg, Bi зэрэг элементийн агууламж багажийн мэдрэх чадвараас бага байв. Бусад элементийн хувьд АНУ-ын Байгаль орчны агентлаг, Канадын Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хоруу чанарын лавламж утгын өгөгдлийн санд орсон 14 элементүүдийн аюулын тоон утгыг тооцоолов (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Бичил элементийн аюулын тоо хэмжээ

Эх үүсвэр / бичил элемент	Суваг-1	Суваг-2	Суваг-3
Al	0.01	0.05	0.01
Ba	0	0.01	0
Fe	0	0.03	0
Mn	0	0.02	0
P	235.33	684.1	0
Sr	0.01	0.02	0.02
Zn	0	0	0
Ni	0	0.01	0.01
Mo	0.1	0.08	0.06
As	1.05	1.53	0.77
Cd	0	0	0
Sb	0.18	0.14	0.11
Tl	0	0	0
U	0.01	0.01	0.04

Эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд P, As зэрэг элементийн аюулын тоон утга 0.2-оос бага буюу хүлцэх эрсдэлтэй байна.

Фосфорын (P) агууламж 18 болон 23-р цэгийн дунд байх үерийн сувгийн ус, Орбитын цэргийн хотхоны арын сувгийн усанд фосфорын агууламж MNS 4943:2015 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага боловч MNS 4585:1998 стандартад 100 мкг/л гэж заасан хэмжээнээс суваг-1-ийн усанд 29 мкг/л-ээр их, суваг-2-ийн усанд 3.75 дахин их илэрлээ. Аюулын тоон утгаар суваг-1 болон суваг-2-ын усанд агуулагдах фосфорын хэмжээ нь үл хүлцэх эрсдэл үүсгэхээр байна. Энэ нь гэр хорооллын нүхэн жорлон, хатуу хог хаягдалтай холбоотой нь илэрхий юм.

Хүнцилийн (As) агууламж Орбитын цэргийн хотхоны арын үерийн сувгийн усанд хүнцилийн агууламж MNS 4943:2015, MNS 4585:1998 стандартуудад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2.6 мкг/л-ээр их, бусад 2 сувгийн усанд дахь агууламж бага байна. Аюулын тоон утгаар 3 сувгийн усанд агуулагдах хүнцилийн агууламж үл хүлцэх эрсдэл үүсгэхээр байна.

Цэгэн бус эх үүсвэр буюу сувгийн усны чанар

Усан орчны мониторингийн судалгааны хүрээнд ерөнхий химийн 28 үзүүлэлт, бичил элементийн 57 үзүүлэлтээр шинжилгээ хийлгэсэн дүнд холбогдох боловсруулалт хийлээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Толгойт орчмын сувгийн усны чанарын мониторингийн нэгдсэн дүн

	“Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм”	Бичил элементийн эрсдэлийн үнэлгээгээр үл хүлцэх эрсдэлтэй элемент
18 болон 23-р цэгийн дунд байх үерийн суваг	Нитрит болон аммонийн азотын агууламж MNS 4586:1998 стандартаас их, исэлдэх чанарын хэмжээгээр “Бага зэрэг бохирдолттой”, аммонийн азот болон нитритийн азотын хэмжээгээр “Маш их бохирдолттой”	P, As
Орбитын цэргийн хотхоны арын суваг	Нитрит азот MNS 4586:1998 стандартаас их, исэлдэх чанарын хэмжээгээр “Бохирдолттой”, аммонийн азотын агууламжаар “Их бохирдолттой”, нитритийн азотын хэмжээгээр “Маш их бохирдолттой”	P, As
15-р цэгийн ойролцоо Орбитын суваг	Исэлдэх чанар, нитритийн азотын хэмжээгээр “Бохирдолттой”, аммонийн азотын агууламжаар “Их бохирдолттой”	As

2.2.2. Газар доорх усны чанар

Толгойт төслийн талбайгаас 2 шугамын ус (УТБ), 5 худгийн уснаас сорьц авсан.

Хүснэгт 7. Толгойт дэд төвийн усан орчны мониторингийн уст цэгүүд

№	Уртраг	Өргөрөг	Тэмдэглэгээ	Дүүрэг	Хороо	Дээжийн нэр
1	47.91981	106.7768	D-11	СХД	2-р хороо	УТБ №211 ШУХА
2	47.91714	106.764	D-28	СХД	34-р хороо	Нарангийн гол, 60-3 тоот, Ш.Доржийн худаг
3	47.91728	106.7667	D-40	СХД	34-р хороо	17-18 цэгийн дунд, Толгойт 664 тоотын хажууд, 221-р худаг
4	47.90054	106.7323	ВН-3	СХД	20-р хороо	ТЭСО ХХК-ын аж ахуйн хашааны худаг
5	47.90201	106.7344	14	СХД	2-р хороо	Экстид ХХК-ын худаг
6	47.92464	106.7335	7	СХД	22-р хороо	Орбит, Хилчин 95-1 тоот, Отгонбаярын худаг
7	47.92438	106.7665	Н-65	СХД	2-р хороо	Нарангийн гол, 27 тоотын эсрэг талд, ШУТБ №222



Зураг 13. Толгойт дэд төвийн усан орчны мониторинг судалгаанд хамрагдсан хугдгууд
УТБ-ны усны температур 9.36-11.01°C-ын хооронд байгаа бол усны орчин сул шүлтлэг рН 7.63-7.75 байна. Худгийн усны температур 4.1-8.78°C-ын хооронд байгаа бол усны орчин саармагаас сул шүлтлэг рН 6.94-7.55 байна.

Гүний усны химийн шинжилгээний дүнг Хүснэгт 8-т өгч, уст төрөл тус бүрээр нь үр дүнгийн боловсруулалт хийв.

Ус түгээх байрны ус (УТБ): УТБ №211 болон УТБ №222 гэсэн цэгүүдээс сорьц авч хэмжилт хийхэд химийн найрлагын хувьд УТБ №211-ын ус гидрокарбонатын ангийн, кальци, натрийн бүлгийн, 1-р төрлийн устай, УТБ №222-ын ус гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн устай байна. УТБ-уудын ус нь чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн, “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна (Хүснэгт 8).



УТБ №211



УТБ №222

Зураг 14. Ус түгээх байр

Хүснэгт 8. Гүний усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан газрын нэр	MNS 0900:2018	УТБ №211	УТБ №222	Ш.Доржийн худаг	221-р худаг	“ТЭСО” ХХК худаг	“Экстид” ХХК худаг	Отгонбаярын худаг	
Сорьц авсан хугацаа /2022 он/		07.28	07.30	07-30	07.30	07.30	07.30	07.30	
Эрдэс, мг/л	1000	84.5	103.1	1126.2	409.1	666.7	659.2	495.1	
Хатуулаг (мг-экв/л)	7	0.69	1	13.89	4.6	6.94	6.68	5.31	
ПИЧ	10	1.44	2.24	2.24	1.12	1.12	1.44	1.6	
NH ₄ ⁺	3	0	0	0	0	0	0	0	
NO ₂ /NO ₃	1.5 /50.0	0.0/0.0	0.0/0.0	0.0/120	0.0/1.0	0.1/18	0.0/17	0.0/2	
Индекс		C _{CaNaI}	C _{CaII}	C _{CaIII}	SC _{CaII}	CC _{CaIII}	C _{CaIII}	C _{CaII}	
Үндсэн элементүүд	CO ₃ ⁻ /HCO ₃ ⁻	-	0/48.8	0/54.9	0/384.3	0/146.4	0/256.2	0/262.3	0/298.9
	Cl ⁻	350	6.4	11	133.1	29.8	121.1	111.5	29.8
	SO ₄ ²⁻	500	7	11	195	120	85	85	40
	Na ⁺ +K ⁺	200	10	9.2	49.6	26.6	62.9	64.4	29.8
	Ca ²⁺	100	9.8	16	191.4	74.5	99.4	96	76.4
Mg ²⁺	30	2.4	2.4	52.8	10.7	24.1	23	18.2	

Ш.Доржийн худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 34-р хороо, Нарангийн гол 60-3 тоот айлын эзэмшилд байх бөгөөд 2013 онд гаргасан, 52 м-ийн гүнтэй, халуун ус болон ойрын айлууд унд ахуйдаа хэрэглэдэг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 1-р төрлийн устай байна. Чанарын хувьд давсархаг, маш хатуу, нийт эрдэжилт, ерөнхий хатуулаг, кальци, магни, нитратын ионууд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангахгүй байна.



Зураг 15. Ш.Доржийн худаг

221-р худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 34-р хороо, Толгойтын 664 тоотын хажууд байрладаг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос сульфат-гидрокарбонатын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 2-р төрлийн устай байна.



Зураг 16. 221-р худаг

Чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр, шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

“ТЭСО” ХХК-ны худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 20-р хороо, “ТЭСО” ХХК-ны аж ахуйн хашаанд байрладаг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонат-хлорын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 3-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар, шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.



Зураг 17. “ТЭСО” ХХК-ны худаг

“Экстид” ХХК-ны худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 20-р хороо, “Экстид” ХХК-ны аж ахуйн хашаанд байрладаг, компанийн 10-аад ажилчин уудаг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 3-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар, шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.



Зураг 18. “Экстид” ХХК-ны худаг


Отгонбаярын худаг: Энэхүү худаг нь СХД-ийн 22-р хороо, Орбит, хилчин 95-1 тоот айлын хашаанд байрладаг, 2011 онд гаргасан, 66 м-ийн гүнтэй. Ойр орчмын айлууд усаа авч уудаг. Тус худгийн усны химийн шинжилгээний дүнгээс харахад найрлагын хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж, катионоос кальцийн ион давамгайлсан, 2-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэг, хатуувтар, шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна (Хүснэгт 8).



Зураг 19. Отгонбаярын худаг

Бичил элементийн шинжилгээний дүн

Бичил элементийн дэлгэрэнгүй шинжилгээг “SGS IMME Mongolia” ХХК-ийн лабораторид хийлгэсэн бөгөөд тус дэд төвийн төслийн талбайн судалгаанд хамрагдсан цэгүүдээс Ш.Доржийн худгийн усанд стронций ундны усны стандартаас 1.2 дахин их буюу 2422 мкг/л илэрсэн байна. Цаашид давтан шинжилгээгээр баталгаажуулах шаардлагатай.



Зураг 20. Гүний усанд агуулагдах бичил элементийн агууламж



Гүний уст цэгийн уснаас авсан дээжид хийсэн шинжилгээний дүнгээр эдгээр цэгүүдэд Al, Ba, Cr, Cu, Fe, Mn, P, Ti, V, Zn, Be, Co, Ni, Ga, Se, Nb, Ag, Cd, In, Sn, Te, Cs, Lu, Hf, Ta, Hg, Ti, Pb, Bi зэрэг элементийн агууламж багажийн мэдрэх чадвараас бага байв. Бусад элементийн хувьд АНУ-ын Байгаль орчны агентлаг, Канадын Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хоруу чанарын лавламж утгын өгөгдлийн санд орсон 16 элементүүдийн аюулын тоон утгыг тооцоолов (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Усны чанарын эрсдэлийн үнэлгээний аюулын тоон утга

№	Эх үүсвэр/бичил элемент	As
1	УТБ №211 ШУХА	0.71

2	Нарангийн гол, 60-3 тоот, Ш.Доржийн худаг	0.55
3	17-18 цэгийн дунд, Толгойт 664 тоотын хажууд, 221-р худаг	0.20
4	ТЭСО ХХК-ын аж ахуйн хашааны худаг	0.33
5	Экстид ХХК-ын худаг	0.30
6	Орбит, Хилчин 95-1 тоот, Отгонбаярын худаг	0.22
7	Нарангийн гол, 27 тоотын эсрэг талд, ШУТБ №222	0.08

Бүх худгуудын усанд агуулагдах хүнцлийн агууламж MNS 6148:2010 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага боловч хоруу чанарын үйлчлэлээр авч үзвэл үл хүлцэх эрсдэлтэй байна. Гадаргын усны шинжилгээний дүнгээр хүнцлийн агууламж мөн үл хүлцэх эрсдэлтэй гарсан. Гэр хорооллын айл өрхийн нүүрсний хэрэглээтэй холбоотойгоор үнсний хаягдал хурын усаар дамжин хөрсөнд нэвчиж гүний усыг бохирдуулж байж болзошгүй байна.



Зураг 21. Гүний усанд агуулагдах As-ийн тархалт, эрсдэлийн зураглал

Гэр хорооллын нягтшил ихтэй, нам дор газар байрлах худгуудын усанд агуулагдах As-ыг агууламж их байна. Тухайлбал 1287 м өндөрт орших D28 цэгт хүнцлийн агууламж 4.54 мкг/л буюу хамгийн их, 1252 м өндөрт орших ВН-3 цэгт 2.69 мкг/л, 1256 м өндөрт орших 14-р цэгт 2.46 мкг/л, харин гэр хорооллын нягтшил бага, 1290 м өндөрт орших 7-р цэгт 1.77 мкг/л байна.


Бактериологийн шинжилгээний үр дүн

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн лавлагаа лабораторид бактериологийн бактерийн ерөнхий тоо, Escherichia coli, Salmonella spp, гэдэсний бүлгийн нян гэсэн 4 үзүүлэлтээр худгуудын уснаас 2022 оны 07-р сарын 31-ны өдөр авсан дээжид хийсэн шинжилгээний дүнгээр Escherichia coli, Salmonella spp, гэдэсний бүлгийн нян илрээгүй боловч “Экстир” ХХК-ны худгийн усанд нийт нянгийн тоо 100-аас ихгүй байхаас 210 илэрч, ундны усны стандартаас 2.1 дахин их байна. Бусад цэгүүдэд нянгийн бохирдолгүй байна.

2.3. Толгойт дэд төв орчмын хөрсөн бүрхэвчийн хими, физик шинж чанар

Хөрсний урвалын орчин (pH). Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг.


Дээж авсан цэгүүдийн хөрсний дээжийн (n=21) 87.5 % нь дунд зэрэг шүлтлэг, (n=1) 4.2% нь хүчтэй шүлтлэг (S-20), (n=2) 8.3% нь сул шүлтлэг (S-12, S-24) орчинтой байна. Хөрсний ихэнх хэсэгт шүлтлэг шинж давамгайлж байна. Улаанбаатар хотын ихэнх хэсгийг эзлэх уулын хархүрэн хөрсний өнгөн хэсэг нь саармаг, доод үе давхарга нь шүлтлэг орчинтой байдаг (Д.Доржготов, 2009). Эндээс үзвэл дээж авсан цэгүүдэд хөрс элэгдэлд орж доод үе давхарга нь дээд үе давхаргатайгаа холилдсонтой холбоотой байж болно.



Зураг 22. Хөрсний урвалын орчин

Хөрсний ялзмаг буюу органик карбон (C). Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг


сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг.



Зураг 23. Хөрсний ялзмагийн агууламж, %

Дээж авсан цэгүүдийн хөрсний ялзмагийн агууламжаар (n=3) 12.5 % нь маш бага, (n=13) 54.2% нь бага, (n=8) 33.3% нь дунд зэрэг ялзмагийн агууламжтай байна.

Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС). Хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг ЕС-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг.




Зураг 24. Хөрсний цахилгаан дамжуулах чанар

Дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүд цахилгаан дамжуулалтаар (n=12) 50.0 % нь сул, (n=9) 37.5% нь дунд, (n=3) 12.5% нь маш их цахилгаан дамжуулалттай байна.


Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K2O). Хөрсний азот, фосфор, кали (N, P, K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксиныг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Хөрсөн дэх калийн исэл (K2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг.

Дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүдэд хөрсөн дэх фосфорын пентоксид (P₂O₅)-ийн агууламжаар (n=17) 70.8 % нь бага хангамжтай, (n=7) 29.2% нь сайн хангамжтай байна.



Зураг 25. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P2O5)-ийн агууламж

Дээж авсан цэгүүдийн хөрсний дээжүүдэд хөрсөн дэх калийн исэл (K2O)-ийг агууламжаар (n=2) 8.3 % нь бага хангамжтай, (n=22) 91.7% нь сайн хангамжтай байна.



Зураг 26. Хөрсөн дэх калийн исэл (K2O)-ийг агууламж

2.4. Толгойт дэд төвийн ургамлын нөмрөг

Толгойтын гэр хорооллын орчимд нийтдээ 25 овог, 57 төрөлд хамаарах 90 зүйл ургамал бүртгэгдэв. Ургамлын бүлгэмдэл зүйн гарал үүслийн хувьд үзэхэд ихэнхдээ хөл газрын

